



**ЗОРИГ САН**  
**ZORIG FOUNDATION**

***Авлигатай тэмцэхэд  
мэдээллийн үүрэг***

# Оршил

**“Авлига”** гэж төрийн улс төр, захиргаа, тусгай албан тушаалд байнга, эсхүл түр хугацаагаар томилогдсон буюу сонгогдсон албан хаагч, төрийн болон орон нутгийн өмчит, түүнчлэн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон захиргааны албан тушаалтан, олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, Ерөнхий захирал, төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу түр буюу байнга гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах болон гүйцэтгэх ажилтан, сонгуульд нэр дэвшигч этгээдүүд албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн

## Оршил

Авлигатай тэмцэх зорилготой “Авлигын эсрэг хууль”,  
“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг  
хэрэгжүүлэх  
бие даасан хараат бус АТГ байгууллага ажиллаж  
байгаа  
хэдий ч авлигын хамрах хүрээ, учруулж буй хор уршиг  
нь  
нийгмийн хөгжилд саад учруулж байгааг судалгааны  
дүн  
нотолж байна. Авлигалтай тэмцэх хамгийн гол зүйл  
**“Мэдээллийн ил тод байдал”** хангахгүй байгаатай  
холбоотой гэж үзэж байна.

# Авлигатай тэмцэхэд мэдээлэл ил тод нээлттэй байхын ач холбогдол

- ❑ Мэдээлэл олж авах эрх, мэдээллийг нээлттэй болгоход /Жишээ нь: төрийн албан хаагч орлогоосоо хэт давсан хэрэглээний зүйл хувьдаа худалдан авсан тохиолдолд хэвлэл мэдээллийнхэн хардаж мэдээлэх эрхтэй./
- ❑ Иргэдийн оролцоог нэмэгдүүлж хяналт тавих боломж бий болгоход
- ❑ Өрсөлдөөний тэгш байдлыг хангахад
- ❑ Төрийн байгууллагын хүнд сурталыг багасгаж, үйлчилгээг шуурхай болгоход
- ❑ Иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэхэд
- ❑ Давуу эрх, тэгш бус эрхийг урвуулан ашиглахыг таслан зогсооход

# Авлигатай тэмцэхэд хэвлэл мэдээллийн гүйцэтгэх үүрэг

- Олон нийтэд мэдээлэл хүргэхдээ чөлөөт, хараат бус байх /хэвлэл мэдээллийн хэрэгсэл хараат бус байгааг төрийн албан хаагчдын үйл ажиллагааг хянах үүргээ хэрхэн биелүүлж буйгаар хэмждэг/
- Хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалыг хянах
- Авлигыг илчилж мэдээлэх
- Авлигатай тэмцэхийн чухалыг олон нийтэд ойлгуулах
- Авлигыг үл тэвчих үзэл, хандлагыг төлөвшүүлэх
- Соён гэгээрүүлэх
- Эрэн сурвалжлах

# Төрөөс мэдээллийг нээлттэй байлгах, түүний хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр хийсэн алхамууд

- “Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сүлжээ” буюу [legalinfo.mn](http://legalinfo.mn) сайт  
(Засгийн газрын тогтоол, Сайдын тушаал, Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, Олон улсын гэрээ, Улсын дээд шүүхийн тогтоол, тайлбар)
- Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл
- Хөрөнгө орлогын мэдүүлэг
- Сар бүрийн 20-ны өдөр төрийн байгууллагуудаас зохиогддог “Нээлттэй хаалганы өдөр”

# Төрийн байгууллагын мэдээлэл хүртээмжтэй байх хэлбэрүүд

- Мэдээлэл түгээх самбар
- Мэдээлэл өгөх үүрэгтэй ажилтан
- Вэб сайт
- Тараах материал
- Олон Улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлдэг төслүүдээр

# Мэдээллийн эрх чөлөөний хуулийг баталснаар авлигатай үр дүнтэй тэмцсэн олон улсын туршлагаас

- Шведийн “Хэвлэл Мэдээллийн эрх чөлөө” хуулийн 2-р бүлэгт иргэн бүр албан ёсны мэдээллийг авах эрхтэй гэж заасан байна. Ингэхдээ “Албан ёсны баримт бичиг” гэж юу болохыг тодорхойлсон бөгөөд ямар үед хуулиар хязгаарлаж болохыг давхар тусгасан байна.
- Канадын “Мэдээллийн эрх чөлөө” хуульд Канад улсын иргэн болон Канадад оршин сууж буй иргэдийн аль нь ч засгийн газрын мэдээллийг авах эрхтэй бөгөөд мэдээлэл нь олон нийтэд нээлттэй байх ёстой гэж заасан. Төрийн нууцад хамаарах мэдээллийг олж авах эрх нь харин хязгаарлагдмал ба уг мэдээллийг ил тод болгох шийдвэрийг Мэдээллийн комисс юм уу Холбооны шүүх шийддэг байна.



## Анхаарах зүйлсээс

- ❑ “Мэдээллийн эрх чөлөө”-ний тухай хуулийг батлах
- ❑ Мэдээллийг нээлттэй болгохдоо нууцлах ангилалыг цөөн бөгөөд тодорхой заах
- ❑ Байнгын хяналт шалгалтын үйл ажиллагааг бий болгох
- ❑ Төрийн зарим чиг үүргийг Иргэний нийгмийн байгууллагуудаар гүйцэтгүүлэх
- ❑ Сэтгүүлчдийн ажлын эрсдэлийг багасгах /эрх зүйн орчин, орлого, хараат бус байдал, ёс зүй/
- ❑ Хэвлэл мэдээллийн байгууллагын боловсон хүчин мэргэжлийн түвшинг дээшлүүлэх